



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нийцлийн аудитын тайлан

Орон нутгийн хөгжлийн сангийн 2016 оны хөрөнгийн зарцуулалт



Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг хууль журмын дагуу зохион байгуулсан ч сангийн хөрөнгийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт, дотоод хяналт хангалтгүй байна.

Арвайхээр 2017 он

ҮАГ-НАГ/2017/01-НА

АГУУЛГА

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Тайланг бэлтгэсэн:

*Дарга, тэргүүлэх аудитор
Л.Ламаачин*

*Аудитын менежер
Ц.Отгонням*

*Ахлах аудитор
Д.Гансүх*

*Аудитор
П.Хорлоосүрэн*

2017 оны 4 дүгээр сар

*Уг тайланг ААГ-ын
Uvurkhangai_audit@audit.gov.mn
Fasebook хаягаар орж үзнэ үү.*

*Аудитын тайлан, дүгнэлттэй
холбоотой асуудлаар нэмж
тодруулах, асууж лавлах зүйл
байвал:*

утас: 70323108, факс 70323253

ХАЯГ:

*(Өвөрхангай аймаг, Арвайхээр сум,
5 дугаар баг, Нутгийн удирдлагын
ордон 402 тоот)*

Товчилсон үгийн тайлбар

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Бүлэг 1 Аймгийн ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэрийг хууль, журамд заасны дагуу төлөвлөөгүй, орлогын нэр төрлөөр бүрдүүлээгүй ч хууль, журмын дагуу хуваарилсан байна.

Бүлэг 2 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг хууль журмын дагуу зохион байгуулсан ч хөрөнгийг зориулалт бусаар зарцуулах, ажлыг дутуу буюу чанаргүй хийх, гэрээт хугацааг хэтрүүлэх, санхүүжилтээ аваад ажлаа хийгээгүй төсөл арга хэмжээ гарсан байна.

Бүлэг 3 Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг зохион байгуулаагүй, хэрэгжилтийг зааврын дагуу тайлагнаагүй байна.

Дүгнэлт:

Зөвлөмж:

Холбогдох байгууллагын санал:

Саналд өгсөн тайлбар

Хавсралтууд

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ҮАГ	Үндэсний аудитын газар
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар
ХАА	Худалдан авах ажиллагаа
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ХОХБТХ	Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ИНХ	Иргэдийн нийтийн хурал
УИХ	Улсын их хурал
НАГ	Нийцлийн аудитын газар
ХХК	Хувийн хувьцаат компани
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
ХТШ	Хязгаарлагдмал тендер шалгаруулалт
ТАХ	Төсөл арга хэмжээ
СХДАХ	Санхүүгийн хяналт, дотоод аудитын хэлтэс
ХААА	Худалдан авах ажиллагааны алба
ХЗА	Хотын захирагчийн алба
ТҮК	Тохжилт үйлчилгээний компани
МУ	Монгол улс

Ерөнхий зүйл

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2017 оны “Аудитын сэдэв батлах тухай” 02 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторт аймгийн Аудитын газраас 2017 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан ҮАГ-НАГ/2017/01-НА төлөвлөгөөг үндэслэн Өвөрхангай аймгийн 2016 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтад аудитыг хийж гүйцэтгэв.

1. Аудитын зорилт:

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн 2016 оны төлөвлөлт, зарцуулалт, түүнд тавих хяналтыг хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулсан эсэхэд аудит хийж, гарсан зөрчлийг арилгах, цаашид сайжруулах санал, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, аудитын дүнг ҮАГ-т танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв.

Үүнд:

- ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэрийг хууль, журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан эсэх.
- ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг хууль журамд заасны дагуу төлөвлөж, гүйцэтгэсэн эсэх.
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, хэрэгжилтийг зааврын дагуу тайлагнасан эсэх.

2. Аудитын хамрах хүрээ:

Энэхүү аудитыг Өвөрхангай аймгийн 19 сумын ИТХ, ЗДТГ, аймгийн ЗДТГ-ын СТСХ, ХОХБТХ, аймгийн ЗД-ын дэргэдэх ГХБХБГ, Орон нутгийн өмчийн газар, Багийн ЗД, ИНХ зэрэг байгууллагуудыг хамруулан ОНХС-ийн хөрөнгийн 2016 оны төлөвлөлт, бүрдүүлэлт, хуваарилалт болон хэрэгжүүлсэн хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт, тайлагнал зэрэгт үндэслэн бодит байдлыг газар дээр нь үзэж, холбогдох бусад баримт материалуудад тулгуурлан аудитыг хийж гүйцэтгэв.

3. Аудитад хэрэглэсэн арга зүй:

Аудитыг АДБОУС 100, 400, 4100, Төрийн хяналт шалгалтын стандарт, Нийцлийн аудитын түр журмыг баримтлан шалгагдагч байгууллагаас авсан мэдээлэл, нотлох зүйлсийг нягтлан шалгах, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, санал асуулга авах, харьцуулах, дүн шинжилгээ хийх, түүвэрлэлт хийх болон аудитын бусад горим, арга зүйг ашигласан болно.

4. Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:

Аудитын зорилттой холбоотой дараах хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг шалгуур болгон ашиглав. Үүнд:

- Төсвийн тухай хууль.
- Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хууль.
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль.
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль.
- Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоол.
- Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”.
- Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”.
- Аймаг, сумдын ИТХ-ын шийдвэр, ЗД-ын захирамж шийдвэрүүд
- Бусад холбогдох хууль, дүрэм, журам.

5. Аудитын стандартын талаарх мэдэгдэл:

Энэхүү аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан аудитын ҮАГ-НАГ/2017/01-НА төлөвлөгөө, хөтөлбөрийг мөрдөж ажиллав. Төрийн хяналт, шалгалтын стандарт, аудитын журамд заасны дагуу аудитын дүгнэлтэд дэмжлэг болох, нотлох зүйлс, холбогдох бусад мэдээллийг ажлын баримт материалд хавсаргав.

6. Аудит хийх багийн бүрэлдэхүүн:

Аудитын явцыг аймгийн Тэргүүлэх аудитор, Аудитын газрын дарга Л.Ламаачин хянан удирдаж, аудитын менежер Ц.Отгонням аудитын стандарт, арга зүйн дагуу хяналт тавьж, ахлах аудитор Д.Гансүх, аудитор П.Хорлоосүрэн, шинжээч Ө.Ринчинмядаг нар 2017 оны 3 дугаар сарын 03-ны өдрөөс 04 дүгээр сарын 28-ны өдрүүдэд хийж гүйцэтгэв.

Аудитаар 729.5 сая төгрөгийн үр өгөөж тооцож, 17 төрлийн 729.5 сая төгрөгийн албан шаардлагыг аймаг, сумдад хүргүүлж байна.

7. Ерөнхий мэдээлэл:

Аймгийн ИТХ-ын 2015 оны 12 дугаар сарын 02-ны 12/08 тогтоолоор Өвөрхангай аймгийн 2016 оны ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний жагсаалтыг аймгийн ОНХСанд 1777.8 сая төгрөг, сумдын ОНХСанд 2666.7 сая төгрөг, нийтдээ 4444.6 сая төгрөгийг баталсан бол аймгийн ИТХ-ын 2016 оны 09 дүгээр сарын 28-ны 2/02 тогтоолоор Өвөрхангай аймгийн 2016 онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний жагсаалтыг аймагт 1377.7 сая төгрөг, сумдад 2066.6 сая төгрөг, нийтдээ 3444.3 сая төгрөг болгон бууруулан баталсан байна.

Аймгийн ОНХС-аас сумдын ОНХС-д олгох шилжүүлгийг тооцохдоо Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг тооцох аргачлал”-ыг мөрдсөн байна.

Аймаг, сумдын удирдлага улсын төсвөөс орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор хуваарилагдсан хөрөнгийг төлөвлөх, батлах, хуваарилах, нутгийн захиргаа, иргэд, олон нийтийн оролцоотой хамтын шийдвэрээр ил тод хариуцлагатай захиран зарцуулах, хяналт тавих, тайлагнах үйл ажиллагааг Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”, 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ыг баримтлан хэрэгжүүлэн ажиллажээ.

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 2016 онд аймгийн ОНХС-д 1420.4 сая төгрөгийн, сумдын ОНХС-д 2023.9 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус олгож жилийн эцэст дансандаа 79.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр аймаг, сумдад он дамжин үргэлжлэх 220.4 сая төгрөгийн, шинэ онд хэрэгжүүлэх 3444.3 сая төгрөгийн, бусад эх үүсвэрээс 68.6 сая төгрөгийн, нийтдээ 3733.4 сая төгрөгийн төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр эх үүсвэр бүрдүүлсэн байна.

Аймаг, сумдын ИТХ-аар батлагдсан 226 төсөл арга хэмжээний 3,894.3 сая төгрөгийн ажлаас 211 төсөл арга хэмжээний 3,722.7 сая төгрөгийн ажилд гэрээ байгуулж, тайлант хугацаанд бүрэн хэрэгжсэн 196 төсөл арга хэмжээний 3,558.7 сая төгрөгийн ажил, дутуу хэрэгжсэн 15 төсөл арга хэмжээний 164.0 сая төгрөгийн ажил, огт хэрэгжээгүй 15 төсөл арга хэмжээний 148.9 сая төгрөг байна.

Аймаг, сумдын ОНХС-аар хийгдэх ажлын 52.4 хувийг НТШ, 3.4 хувийг ХТШ-аар, 20.3 хувийг харьцуулалтын арга, 15.8 хувийг шууд худалдан авах, олон нийтийн оролцооны аргаар зохион байгуулжээ.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг хууль журмын дагуу зохион байгуулсан ч сангийн хөрөнгийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт, дотоод хяналт хангалтгүй байна.

Нэг. Аймгийн ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэрийг хууль, журамд заасны дагуу төлөвлөөгүй, орлогын нэр төрлөөр бүрдүүлээгүй ч хууль, журмын дагуу хуваарилсан байна.

1.1 Аймгийн ОНХС-аас олгох орлогын шилжүүлгийг батлагдсан аргачлалын дагуу орон нутгийн хөгжлийн индекс, хүн амын тоо, хүн амын нягтрал, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээ, орон нутгийн татварын идэвх санаачилга зэргийг харгалзан тооцож төлөвлөсөн байна.¹

Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.2-т заасны дагуу ОНХС-ийн шилжүүлгийн 60-аас доошгүй хувийг сум, дүүргийн ОНХС-д хуваарилахаар хуульчлан баталсны дагуу аймаг орон нутгийн хөгжлийн сангаас 3444.3 сая төгрөгийн 60 хувь буюу 2066.6 сая төгрөгийг сумдад, 40 хувь буюу 1377.7 сая төгрөгийг аймагт Төсвийн тухай хуулийн 59.3-д заасны дагуу орон нутгийн хөгжлийн индекс, хүн амын тоо, хүн амын нягтрал, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээ, орон нутгийн татварын идэвх санаачилга зэргийг харгалзан сумдад хуваарилан тооцож, төлөвлөсөн байна.

1.2 Аймаг, сумдын ОНХС-ийн эх үүсвэрийг төлөвлөхдөө төсвийн төсөл боловсруулах журамд заасан нэр төрлөөр тооцож төлөвлөөгүй байна.²

Аймгийн ИТХ-ын 2015 оны 12 дугаар сарын 02-ны 12/08 тоот тогтоолоор ОНХСангийн хөрөнгийг 4444.6 сая төгрөгөөр баталсан ба 2016 оны 09 дүгээр сарын 28-ны ИТХ-ын тэргүүлэгчдийн 2/02 тоот тогтоолоор дахин тодотгож 3444.3 сая төгрөгөөр ОНХСангийн санхүүжилтийг баталсан байна.

Аймаг, сумдын ОНХС-ийн эх үүсвэрийг төлөвлөхдөө төсвийн төсөл боловсруулах журамд заасан орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох орлогын шилжүүлгээр орлогыг төлөвлөсөн ч үндсэн тэнцлийн ашгийн суурь зарлагатай тэнцэх хэсэг, татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх замаар бий болгох эх үүсвэр, зарлагыг хэмнэх замаар бий болгох эх үүсвэр, тухайн орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор авах дотоод гадаадын хандив, тусламжийн орлого гэсэн нэр төрлөөр тооцож төлөвлөөгүй байна.

1.3 Аймаг, сумдын ОНХС-ийн эх үүсвэрийг хуульд заасан ОНХС-аас хуваарилагдсан шилжүүлгийн орлогоос бүрдүүлж, бусад эх үүсвэрийг дайчлан ажиллаж чадаагүй байна.

Тус аймгийн ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэр нь ОНХС-аас хуваарилагдсан шилжүүлгийн орлогоос бүрдэж байгаа бөгөөд төсвийн үндсэн тэнцлийн ашиг болон орлого нэмэгдүүлэх замаар

¹ Төсвийн тухай хуулийн 59.3.Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас тухайн жил орон нутгийн төсөвт олгох шилжүүлгийг тодорхойлохдоо дараах итгэлцүүрийг үндэслэн тогтооно:

- 59.3.1.орон нутгийн хөгжлийн индекс;
- 59.3.2.хүн амын тоо;
- 59.3.3.хүн амын нягтрал, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээ;
- 59.3.4.орон нутгийн татварын идэвх санаачилга.

59.4.Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг орон нутагт хуваарилахдаа ашигт малтмалын олборлолт хийгдсэн тухайн орон нутгийн нэг хүнд ногдох хэмжээг бусад орон нутгийн нэг хүнд ногдох хэмжээнээс 10 хүртэл хувиар нэмэгдүүлэн тогтооно.

59.5.Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон Орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлгийг тооцох аргачлалыг Засгийн газар батална.

² 60.2.Орон нутгийн хөгжлийн сан нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

- 60.2.1.Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг;
- 60.2.2.энэ хуулийн 59.2-т заасан хөрөнгө;
- 60.2.3.энэ хуулийн 56.2-т заасан орон нутгийн төсвийн үндсэн тэнцлийн ашиг;
- 60.2.4.татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх болон зарлагыг хэмнэх замаар бий болгосон нэмэгдэл эх үүсвэр;
- 60.2.5.тухайн орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоод, гадаадын хандив, тусламж.

бий болсон төсвийн бусад эх үүсвэр, хандив, тусламжийн орлогын эх үүсвэрээр төлөвлөн бүрдүүлж чадаагүй байна.

Харин Хужирт сум самар борлуулсны орлогоор 57.9 сая төгрөг, Бсөнзүйл сум урд оны актын төлбөрийн орлогоор 3.5 сая төгрөг, аймгийн ОНХСанд бусад орлогоор 7.2 сая төгрөгийн орлого бүрдүүлж, бусад сумд орлого бүрдүүлээгүй байна.

Хүснэгт 1: ОНХС-д төвлөрүүлсэн орлого **/сая төгрөг/**

д/д	Сумдын нэр	Өмнөх оны үлдэгдэл	ОНХНС болон аймаг нийслэлийн ОНХС-аас шилжүүлсэн санхүүжилт	Бусад орлого		Нийт эх үүсвэр
				төлөв	гүйц	
1	Аймгийн ОНХС	97.9	1420.3		7.2	1525.4
2	Баян-Өндөр	25.8	90.1			115.9
3	Бүрд	9.1	85.6			94.7
4	Бат-Өлзий	4.4	103.7			108.1
5	Баруунбаян-Улаан	14.8	122.3			137.1
6	Баянгол		88.9			88.9
7	Гучин-Ус		102.4			102.4
8	Бсөнзүйл		75.6		3.5	79.1
9	Өлзийт		74.9			74.9
10	Зүүнбаян-Улаан		81.6			81.6
11	Богд	57.2	139.1			196.3
12	Нарийнтээл		94.2			94.2
13	Сант		80.3			80.3
14	Тарагт		83.4			83.4
15	Төгрөг	6.2	110.1			116.3
16	Уянга		124.0			124.0
17	Хайрхандулаан		104.4			104.4
18	Хужирт		98.2		57.9	156.1
19	Хархорин	5.0	137.8			142.8
20	Арвайхээр		227.4			227.4
	Аймгийн нийт дүн	220.4	3444.3	0.0	68.6	3733.3

Аймаг сумдын удирдлагууд “Төсвийн тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 14 дүгээр зүйлийн 14.2.2, Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 6.1.2, 6.1.3, 6.1.4, 6.1.5 дахь заалт болон 6.2.2, 6.2.3, 6.2.4, 6.2.5 дахь заалтын дагуу ОНХС-ийн хөрөнгийн бусад эх үүсвэрийг хууль, журамд заасан нэр төрлөөр нь бүрдүүлэх талаар идэвх санаачлаггүй ажилласан байна.

1.4 Аймгийн ОНХС-аас олгосон шилжүүлгийг аймагт 40 хувь, сумдад 60 хувийн харьцаагаар хууль, журмын дагуу хуваарилж, батлагдсан хуваарийн дагуу санхүүжилтийг жигд хийгдээгүйгээс зарим сумдад санхүүжилтийг бүрэн олгоогүй байна.³

Аймгийн Засаг даргын 2016 оны 03 дугаар сарын 17-ний өдрийн а/122 тоот захирамжаар сумдын ОНХСанд 2666.7 сая төгрөг, аймгийн ОНХСанд 1777.8 сая төгрөг, нийтдээ 4446.0 сая төгрөгөөр төсвийн хуваарийг баталсан ба мөн аймгийн Засаг даргын 2016 оны 10 дугаар сарын

³59.2.Аймаг, нийслэл нь орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгосон шилжүүлгийн 60-аас доошгүй хувийг сум, дүүргийн хөгжлийн санд энэ хуулийн 59.3-т заасан үзүүлэлтийг харгалзан хуваарилна.

07-ны өдрийн а/450 тоот захирамжаар сумдын ОНХСанд 2066,6 сая төгрөг, аймгийн ОНХСанд 1377,7 сая төгрөг, нийтдээ 3444,3 сая төгрөгөөр төсвийн хуваарийг тус тус баталсан байна.

Хүснэгт 2: ОНХС-н батлагдсан төсөв

/сая төгрөг/

ОНХС-аас олгосон санхүүжилт					
Д/д	Аймаг, сумдын нэр	Батлагдсан дүн	Шилжүүлсэн дүн	Зөрүү	Санхүүжилт ийн хувь
1	Өвөрхангай аймаг	1377.7	1420.4	42.7	103.1
2	Баян-Өндөр сум	93.9	90.1	-3.8	95.9
3	Бүрд сум	87.1	85.5	-1.5	98.1
4	Бат-Өлзий сум	106.3	103.7	-2.6	97.5
5	ББУлаан сум	106.1	122.3	16.2	115.2
6	Баянгол сум	95.0	88.9	-6.1	93.6
7	Гучин-Ус сум	109.5	102.4	-7.1	93.5
8	Есөнзүйл сум	80.9	75.7	-5.2	93.6
9	Өлзийт сум	80.2	75.0	-5.2	93.5
10	ЗБУлаан сум	88.1	81.6	-6.5	92.6
11	Богд сум	150.7	139.1	-11.6	92.3
12	Нарийнтээл сум	94.2	94.2	0	100.0
13	Сант сум	85.8	80.2	-5.6	93.5
14	Тарагт сум	92.5	83.3	-9.2	90.0
15	Төгрөг сум	113.4	110.1	-3.3	97.1
16	Уянга сум	118.7	124.0	5.3	104.5
17	Хайрхандулаан сум	103.4	104.4	1.0	100.9
18	Хужирт сум	97.3	98.2	0.9	100.8
19	Хархорин сум	135.8	137.8	2.0	101.5
20	Арвайхээр сум	227.4	227.4	0	100.0
Дүн		3444.3	3444.3	0	100.0

ОНХСангийн аймаг сумдад олгосон шилжүүлгийг хууль, журмын дагуу хуваарилж, баталсан ч, хуваарийн дагуу санхүүжилт жигд хийгдээгүй, оны эцэст хуримтлагдан орж ирснээс батлагдсан хуваарийн дагуу зарим нэр бүхий сумдад санхүүжилтийг бүрэн олгоогүй байна.

Зөвлөмж: Өвөрхангай аймгийн ИТХ-ын дарга А.Ишдорж, Засаг дарга Г.Ганболд нарт:

- Аймгийн ОНХС-ийн орлогыг төлөвлөхдөө төсвийн зарлагын бодит хэмнэлт, хандив, тусламжийн хөрөнгийг төвлөрүүлэх, хууль, журамд заасан орлогын бусад эх үүсвэрийг дайчлан төлөвлөж, шийдвэртээ тусган хэрэгжүүлэх.

Хоёр. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг хууль журмын дагуу зохион байгуулсан ч хөрөнгийг зориулалт бусаар зарцуулах, ажлыг дутуу буюу чанаргүй хийх, гэрээт хугацааг хэтрүүлэх, санхүүжилтээ аваад ажлаа хийгээгүй төсөл арга хэмжээ гарсан байна.

2.1 Аймаг, сумд ОНХС-ийн хөрөнгийг орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулан төлөвлөж, урьдчилсан саналын жагсаалтыг бэлтгэж ажилласан байна.

Аймаг, сумдын ОНХС-аас санхүүжүүлэх төсөл, хөтөлбөр, арга хэмжээг төлөвлөхдөө Монгол Улсын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, Засгийн газрын мөрийн хөтөлбөр, Өвөрхангай аймгийн эдийн засгийг 2014-2024 онд хөгжүүлэх бодлогын баримт бичиг, аймгийн Засаг даргын 2012-2016 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, аймаг, сумдын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан зорилт арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд чиглүүлэн төсөл, хөтөлбөр, арга хэмжээнүүдийг төлөвлөж хэрэгжүүлсэн байна.

Мөн сумд эдийн засгийн хөгжлийн төлөвлөгөөг /2012-2022 он/ гэх мэтээр 10 жилээр төлөвлөж, энэ дагуу төсөл арга хэмжээг уялдуулан төлөвлөж ажиллажээ.

Аймаг, сумдын Засаг дарга нар ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний төслийн урьдчилсан саналын жагсаалтыг Төсвийн тухай хууль, журмын дагуу боловсруулан иргэдээс багуудын ИНХ-ын үеэр саналыг авч хэлэлцүүлсэн байна.

2.2 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-г иргэдэд нээлттэй хэлэлцүүлэн санал авч байгаа боловч төсвийн хүрэлцээ хомс, урд онуудын саналын эрэмбэлэлтээр ажил хийгдээгүй хойшилсноос иргэдээс авах санал авалт багассан байна.⁴

Аймаг сумдын 2016 оны ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөхдөө сангийн хөрөнгөөр хийх ажлын санал хураалтыг зохион байгуулах ажлын хэсгийг аймаг сумдад байгуулан ажиллуулсан.

Сумд ОНХС-ийн хөрөнгөөр 2016 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг иргэдээс санал авах маягтаар болон олон нийтийн нээлттэй санал асуулга явуулж, багуудын ИНХ-аар хэлэлцүүлэн саналыг тэргүүлэх ач холбогдол бүхий орон нутагт тулгамдсан асуудлуудыг эрэмбэлэн сумын ИТХ-ын тогтоол гарган ажиллажээ.

Тухайлбал: Арвайхээр сум гудамжны гэрэлтүүлэг нэмэгдүүлэх 524 хүний санал 1-рт, багт узельтай болох 520 хүний саналаар 2-рт, камержуулалтын тоог нэмэх 509 хүний саналаар 3-рт гэх мэт эрэмбэлэгдсэн.

Харин Өлзийт, Хайрхандулаан зэрэг сумд 2016 онд хийгдэх төсөл арга хэмжээнд санал авалгүй урд оны санал эрэмбэлэлтээр төсөл арга хэмжээг эрэмбэлж баталсан байна.

Мөн иргэдийн саналаар дэмжигдээгүй ажлыг жагсаалтад оруулж, санхүүжүүлсэн төсөл арга хэмжээ гарсан байна. Тухайлбал:

Богд сумын гүний худгийн усан сангийн камержуулалтын 14.9 сая төгрөгийн ажил, Арвайхээр сумын 1-р 12 айлын орон сууцны цэвэр усны шугам засварын 1.4 сая төгрөгийн ажил,

⁴ Төсвийн тухай хуулийн 63.1.Баг, хорооны Засаг дарга Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх дараалал, арга замын талаар баг, хороодод олон нийтийн нээлттэй санал асуулга явуулна.

63.2.Энэ хуулийн 63.1-д заасан санал болон баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал дээр гарсан саналыг иргэдийн Нийтийн Хурал хэлэлцэн, тэргүүлэх ач холбогдол бүхий төсөл, арга хэмжээг эрэмбэлэн сонгоно.

63.3.Энэ хуулийн 63.2-т заасны дагуу баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлаас ирүүлсэн саналыг сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар ач холбогдол, тухайн орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан эрэмбэлж, төсвийн төсөлд тусган сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ.

нийтдээ 2 төсөл арга хэмжээнд 16.3 сая төгрөгийн хөрөнгийг иргэдийн саналаар эрэмбэлэгдээгүй ажилд албан шаардлага өгч байна. .

Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-г иргэдэд нээлттэй байгаа эсэх талаар санал асуулга авахад санал асуулгын хуудсаар тус аймгийн 13 сумын 310 хүнээс санал авсны 99 нь эрэгтэй, 211 нь эмэгтэй байна.

Боловсролоор нь авч үзвэл: дээд 152, Бүрэн дунд 95, Бүрэн бус дунд 16, Тусгай дунд 13, Бага 8, боловсролгүй 21 хүн хамрагдсан ба насны ангиллаар үзвэл: 18-25 насны 18, 25-30 насны 52, 30-40 насны 69, 40-50 насны 62, 50-60 насны 36, 60-с дээш настай 6 хүн санал асуулгад оролцсон. Үүнд:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтийн ямар төсөл арга хэмжээ танай хороо, сум, дүүрэгт хэрэгжиж буй талаар Та хэр мэдээлэлтэй байна вэ гэсэн асуулгад:

- Санхүүжүүлж буй үйл ажиллагааны жагсаалт, хэрэгжилтийг сайн мэднэ гэж – 98 хүн буюу 31.6 хувь
- ОНХС-аас төсөл, арга хэмжээ санхүүжүүлдэг гэж сонссон, харин манай сум, дүүрэгт ямар арга хэмжээ хэрэгжиж буйг мэдэхгүй гэж 139 хүн буюу 44.8 хувь
- Энэ талаар огт мэдээлэл байхгүй гэж 73 хүн буюу 23.5 хувь нь хариулсан байна.

2. ОНХС-ийн асуудлыг хэлэлцэх баг, хорооны иргэдийн нийтийн хуралд та оролцож байсан уу гэсэн асуулгад: байнга гэж -62 хүн буюу 20.0 хувь, хааяа гэж -150 хүн буюу 48.3 хувь, огт үгүй гэж – 98 хүн буюу 31.6 хувь нь хариулсан байна.

3. Хэрвээ оролцож байсан бол зайлшгүй шаардлагатай асуудлуудыг иргэдээр хэлэлцүүлж чаддаг эсэх талаар таны бодол гэсэн асуулгад:

- Цаанаасаа бэлтгэсэн асуудлуудын жагсаалтыг хэлэлцүүлж санал авдаг – 48 хүн буюу 15.4 хувь
- Оролцогч иргэдээс санал авч дэвшүүлэн хэлэлцүүлдэг – 82 хүн буюу 26.4 хувь
- Дээрх хоёр аль аль нь – 71 хүн буюу 22.9 хувь
- Иргэдийн саналыг бараг сонсдоггүй, нэр төдий хурал болдог гэж -36 хүн буюу 11.6 хувь нь хариулсан байна.

4. ОНХС-гийн санхүүжилтээр хэрэгжүүлэхээр болсон төсөл арга хэмжээний талаар мэдээллийг зарладаг уу гэсэн асуулгад: тийм гэж 116 хүн буюу 37.4 хувь, зарладаг байх, гэхдээ би сонсоогүй гэж 165 хүн буюу 53.2 хувь, огт үгүй гэж 29 хүн буюу 9.3 хувь нь хариулсан байна.

5. ОНХС-аас ямар төсөл арга хэмжээ санхүүжүүлэх боломжтой тухай мэдээлэл болон таны саналыг авах хуудас танай өрхөд ирж байсан уу гэсэн асуулгад:

- Саналын хуудас, мэдээлэл байнга ирдэг гэж 56 хүн буюу 18.0 хувь
- Санал хуудас ирдэггүй ч хурал болох талаар мэдээлэл өгдөг гэж 130 хүн буюу 41.9 хувь
- Санал хуудас ирдэггүй, мэдээлэл ч өгдөггүй гэж 124 хүн буюу 40.0 хувь нь хариулсан байна.

6. ОНХС-гийн санхүүжилтээр хэрэгжүүлж буй төсөл арга хэмжээний хэрэгжилт, ашиглалтад иргэд хяналт тавих бололцоо, механизм байгаа юу гэсэн асуулгад:

бүрэн боломжтой гэж 117 хүн буюу 37.7 хувь, боломжгүй гэж 72 хүн буюу 23.2 хувь, энэ талаар мэдэхгүй байна гэж 121 хүн буюу 39.0 хувь нь хариулсан байна.

7. ОНХС-ийн санхүүжилт, төсөл арга хэмжээний талаарх Таны нэмэлт санал хүсэлт гэсэн асуулгад:

- Төсөл арга хэмжээг байгууллага, иргэдэд чиглэсэн үр дүнтэй, өгөөжтэй, хүртээмжтэй ажилд хөрөнгө оруулалт хийх, санхүүжилтийг нэмэгдүүлэх.
- Сум оронд ажлын байр нэмэгдүүлэх, жижиг дунд үйлдвэр хөгжүүлэх, залуу малчдыг дэмжихэд зарцуулах.
- Мэдээллийг ил тод болгох, шударга, нээлттэй байх, тайлан мэдээллээ иргэдэд тавьдаг байх. Сургалт, сурталчилгаа сайн хийх.
- Тендер шалгаруулалт, санхүүжилт, төсөл арга хэмжээнд тавих хяналтыг сайжруулах. Тендер шалгаруулалтыг шударга явуулах, танил тал, найз нөхдөдөө тендерийг өгдөг явдлыг таслан зогсоох.

- Гудамжны гэрэлтүүлэг, тохижилт, зам талбайд хөрөнгө зарцуулах.
- Иргэдийн оролцоог сайжруулах, зөв оновчтой зүйлд хөрөнгийг зарцуулах, олон нийтэд чиглэсэн хүртээмжтэй ажилд зарцуулах гэсэн багц саналуудыг өгсөн байна.

Дээрх санал асуулгаас дүгнэж үзэхэд: Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилт, төсөл арга хэмжээний талаар 68.4 хувь нь мэдээлэлгүй, ОНХС-ийн асуудлыг хэлэлцэх баг, хорооны иргэдийн нийтийн хуралд 31.6 хувь нь оролцдоггүй, Зайлшгүй шаардлагатай асуудлуудыг иргэдээр хэлэлцүүлж чаддаг эсэхэд иргэдийн саналыг бараг сонсдоггүй, нэр төдий хурал болдог гэж 11.6 хувь, ОНХС-гийн санхүүжилтээр хэрэгжүүлэхээр болсон төсөл арга хэмжээний талаар мэдээллийг зарладаг эсэхэд огт үгүй гэж 9.3 хувь, Саналыг авах хуудас ирдэг эсэхэд саналын хуудас ирдэггүй, мэдээлэл ч өгдөггүй гэж 40.0 хувь, ОНХС-ийн зарцуулалт, ашиглалтад иргэд хяналт тавих бололцоо байгаа эсэхэд боломжгүй болон энэ талаар мэдэхгүй гэж 62.2 хувь нь хариулсан байна.

Зөвлөмж: Аймгийн Засаг дарга Г.Ганболдод:

- ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг иргэдээр нээлттэй хэлэлцүүлж байх.

2.3 "Орон нутгийн хөгжлийн сангийн заавар"-ын 4.7 дахь заалтын шаардлагыг хангасан ТАХ-г хэрэгжүүлсэн байна.⁵

ОНХСангийн хөрөнгөөр санхүүжигдсэн төсөл арга хэмжээ нь хуульд заасны дагуу техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсөв нь батлагдсан, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийгдсэн байна.

Сумд ОНХС-аар хийгдэх ажлын ихэнхийг харьцуулалтын болон шууд худалдан авах, олон нийтийн оролцооны аргаар зохион байгуулж, төсөв тооцоо, үнэлгээг Үнэлгээний хорооноос гаргаж, ажлын даалгавар, техникийн тодорхойлолт, ажлын гэрээнд тусгаж өгсөн байна.

Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр төлөвлөгдсөн томоохон ажлын ТЭЗҮ, зураг төсөв хийгдсэн байна. Тухайлбал: аймгийн төвийн багуудын ӨЭМТөвийн барилгын ажлын зургийг Аркад ХХК боловсруулсан бөгөөд магадлал хийгдсэн.

Харин Баруунбаян-Улаан, Баян-Өндөр сумдын Цэцэрлэгийн барилгын өргөтгөлийн зураг нь Барилгын хөгжлийн төвийн экспертээр хянагдаагүй байна.

Зөвлөмж: Аймгийн Засаг дарга Г.Ганболдод:

- Барилгын экспертээр хянагдаж батлагдсан зураг төсвөөр төсөл арга хэмжээг хэрэгжүүлж байх.

2.4 Төсөл, хөтөлбөрийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг хууль журмын дагуу зохион байгуулсан ч зарим нэг тендерийн шалгаруулалт тодорхойгүй байна.

Аймгийн үнэлгээний хорооны гишүүд бүгд худалдан авах ажиллагааны чиглэлийн сургалтад хамрагдаж сертификат авсан бол сумдын үнэлгээний хорооны гишүүдийн 1-2 нь сертификатгүй байна.

Тендерийн урилга, мэдээллийг Засгийн газрын худалдан авах ажиллагааны "e-procurement.mof.gov.mn", "procurement.ov.gov.mn", "uvurkhangai.mn" сайтууд болон Үндэсний хэмжээний өдөр тутмын сонин болох Монголын үнэн сонин, сумд аймгийн Таны элч сонин болон мэдээллийн самбараар мэдээллээ байршуулсан байна.

⁵ "Орон нутгийн хөгжлийн сангийн заавар"-ын 4.7 дахь заалт Хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээ нь хуульд заасны дагуу техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсөв нь батлагдсан, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийгдсэн, бусад зөвшөөрөлтэй байх.

Тендерийн баримтаас үзэхэд: аймаг, сумд ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл, Үнэлгээний хорооны гишүүнээр ажиллахыг зөвшөөрсөн мэдүүлэг, Тендерийн нээлтийн тэмдэглэл, үнийн саналууд, тендерийг хянан үзэх, маягтуудыг хөтөлжээ.

Аймаг сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх төсөл, хөтөлбөрийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг хууль журмын дагуу зохион байгуулсан байна.

Харин Арвайхээр суманд 150 хүүхдийн цэцэрлэг шинээр барих ажлыг СИЗУ ХХК-ыг 851.5 сая төгрөгөөр гүйцэтгүүлэхээр шалгаруулсан байна.

Гэвч МУ-н Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Ганцогтоос 2016 оны 05 дугаар сарын 20-ны 5/3396 тоотой Тэд констракшн ХХК-ийн гомдлын дагуу гүйцэтгэгч сонгох ажиллагааг түр түдгэлзүүлсэн ба мөн яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Ганцогтын 2016 оны 05 дугаар сарын 30-ны 5/3570 тоотой Тэд констракшн ХХК-ийн гомдлыг хянан үзээд татгалзсан нь үндэслэлгүй байна гэж үзээд тендер шалгаруулалтыг дахин явуулахыг мэдэгдсэн байна.

Гэвч энэ талаар тендер шалгаруулалтыг дахин явуулсан эсэх, тухайн компани гомдлоо эргүүлэн татсан эсэх талаар Сангийн яам болон орон нутгийн Өмчийн газрын ХАААлбаны баримт материал байхгүй бөгөөд СИЗУ ХХК ажил гүйцэтгэх гэрээг байгуулан ажиллаж байна.

Зөвлөмж: Аймгийн Засаг дарга Г.Ганболдод:

- Төсөл, хөтөлбөрийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг хууль, журмын дагуу зохион байгуулж байх.

2.5 ОНХС-ийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулах, дутуу буюу чанаргүй хийх, гэрээт хугацааг хэтрүүлэх, санхүүжилтээ аваад ажлаа хийгээгүй төсөл арга хэмжээ гарсаар байна.⁶

Аудитаар ОНХС-аар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнд дараах зөрчил гарсан байна. Үүнд:

1. Зориулалт бусаар зарцуулсан төсөл, арга хэмжээ:

- Баруунбаян-Улаан, Тарагт, Есөнзүйл, Уянга, Хархорин сумд гамшгаас хамгаалах зардалд 2.6-6.9 сая төгрөг,
- Бат-Өлзий сум гэрэлтүүлгийн урсгал засварын ажлын цалин хөлсөнд 3.4 сая төгрөг,
- Уянга сум хог зайлуултанд 30.0 сая төгрөг, Уянга, Хархорин сумд нохой устгахад 3.7-6.0 сая төгрөг,
- Хархорин, Төгрөг сумд Залуучуудыг дэмжих жилд 5.0 сая төгрөг,
- Хужирт сум Цагдаагийн цахим торгуулийн машин авахад 4.1 сая төгрөг,
- Зүүнбаян-Улаан сумын урт хугацааны “2014-2024 онд хөгжүүлэх хөгжлийн хөтөлбөр” номыг 3.0 сая төгрөгөөр хэвлүүлсэн зэрэг нийтдээ 14 төсөл арга хэмжээнд 79.1 сая төгрөгийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсанд албан шаардлага өгч байна.

⁶ Төсвийн тухай хуулийн 60.3.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулахыг хориглоно:

60.3.1.орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргээс бусад хөтөлбөр, арга хэмжээ,
 60.3.2.улс төрийн нам, төрийн бус байгууллагын зарлага;
 60.3.3.үндэсний их баяр наадмаас бусад баяр, наадам, ойн арга хэмжээ, шашны зан үйлийн болон ёслолын зардал;
 60.3.4.нийтийн эрх ашигт нийцээгүй үйл ажиллагаа;
 60.3.5.зээл олгох, санхүүгийн үр дагавар бүхий баталгаа гаргах, хохирлыг нөхөн төлөх үүрэг авах;
 60.3.6.орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ.

2. Дутуу буюу чанаргүй хийгдсэн, хугацаа хэтэрсэн төсөл арга хэмжээ:

- Бүрд сумын Сургуулийн спорт заалны засварын 57.9 сая төгрөгийн ажил агааржуулалт хийгдээгүйгээс ханын шохой хууларсан.
- Хужирт сумын 2-р Цэцэрлэгийн агааржуулалтын 5.7 сая төгрөгийн ажлын дулаалга муу хийгдсэнээс местелт үүсэж сэнс нь ажиллахгүйгээс хана таазанд хөгц цохисон.
- Өлзийт сумын Бор хошууны багийн хөгжлийн төвийг 49.7 сая төгрөгөөр шинээр барьж, халаалтыг цахилгаан халаагуураар шийдсэн ч разетка цөөн хийгдсэнээс ачааллаа даахгүй, халахгүй байгаа, ЭМТөвийн 9.6 сая төгрөгийн тоног төхөөрөмж зах зээлийн үнээс өндөр чанар хангалтгүй,
- Есөнзүйл сумын СӨББ-ын 5.0 сая төгрөгийн вакум цонхыг хуучин модон рам дээр суулгаснаас салхи сийгдэг,
- Гучин-Ус сумын 5.9 сая төгрөгийн хадлангийн газар хашаалах материал худалдан авах ажил, ашиглагдахгүй байгаа гар худгийг сэргээн засварлах 7.8 сая төгрөгийн ажил, усалгаатай газар тариалангийн 24.5 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн ажил, мал ариутгалын 16.5 сая төгрөгийн машин авах ажлууд бүрэн дуусаж хүлээн аваагүй,
- Арвайхээр сумын Ногоон байгууламж бүхий спорт тоглоомын талбай байгуулах ажлаас сагсны шийд эвдэрсэн, талбайн өнгөлгөөтэй бетон тоосгоны орох хаалганы зүүн тал нурсан, зүлэгжүүлэлт, мод суулгалт бүрэн хийгдээгүй, амрах сандал 5, хогийн сав 2 дутуу, орох гарах хаалгыг эргэгддэг хаалгаар солих, сувгийн дээр сараалж, шүүр тавих, усан оргилуурын бетон шал цутгах ажлууд хийгдээгүй, явган хүний замын хучилт үерийн зэрэг нийтдээ 8.4 сая төгрөгийн ажил дутуу буюу чанаргүй хийгдсэн, хугацаа хэтэрсэнд албан шаардлага өгч байна.
- Аймгийн ОНХСангийн хөрөнгөөр Арвайхээр суманд баригдаж байгаа 150 хүүхдийн цэцэрлэгийн барилгын ажлын явц 60.0 хувьтай байгаа ба үлдэх 40.0 хувь буюу 340.6 сая төгрөгийн ажил гэрээт хугацаандаа дуусаагүй зэрэг нийтдээ 11 төсөл арга хэмжээний 531.6 сая төгрөгийн ажил дутуу буюу чанаргүй хийгдсэн, хугацаа хэтэрсэнд албан шаардлага өгч байна.

Зураг 1: Бүрдний спорт заалны барилга чанаргүй баригдсан байна.**Зураг 2: Хужирт сумын 2-р цэцэрлэгийн агааржуулалтын ажил хийгдсэн боловч хөлдсөний улмаас ажиллаагүй байна.****Зураг 3: Арвайхээр сумын 150 хүүхдийн цэцэрлэгийн ажил хугацаандаа дуусаагүй байна.****Зураг 4: Өлзийт сумын багийн төвийн барилга халаалт байхгүй байна.****3. Хэрэгжээгүй, санхүүжилтээ аваад ажлаа хийгээгүй төсөл арга хэмжээ:**

- Уянга сумын Соёлын төвийн гадна талын тохижилтод 16.2 сая төгрөгийн санхүүжилт хийгдсэн ч ажил хийгдээгүй,
- Хужирт сумын Үерийн далан засварлах 5.0 сая төгрөгийн ажил,
- Сант сумын Орон нутгийн өмчийн орон сууцыг төвлөрсөн халаалтад холбох 17.4 сая төгрөгийн ажил, Үйлчилгээний төвийг цэвэр бохирт холбох 3.7 сая төгрөгийн ажил зэрэг нийтдээ 4 төсөл арга хэмжээний 42.3 сая төгрөгийн ажил хийгдээгүйд албан шаардлага өгөгдөж байна.

Аудитаар нийтдээ 34 төсөл арга хэмжээтэй холбоотой 729.5 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага тавигдсан болно.

График 1: Өвөрхангай аймгийн 2016 оны ОНХС-ийн аудитаар илэрсэн зөрчлийн төрлөөр

/сая төгрөг/

Өвөрхангай аймгийн 2016 оны ОНХС-ийн аудитаар илэрсэн зөрчил /албан шаардлага/



Зөвлөмж: Аймгийн Засаг дарга Г.Ганболд болон сумдын Засаг дарга нарт:

- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан, ажлыг чанаргүй, дутуу гүйцэтгэсэн байгууллага, аж ахуйн нэгжийн удирдлага, хүмүүст хариуцлага тооцох.
- Гүйцэтгэл дутуу байгаа болон санхүүжилтээ аваад ажлаа хийгээгүй төсөл арга хэмжээг энэ оны эхний хагас жилд багтаан дуусгаж хүлээн авах.

2.6 Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд захиалагчийн хяналтыг аймгийн ЗДТГ-ын ХОХБТХэлтэс болон ЗД-ын дэргэдэх ГХБХБГ-аас тавьж ирсэн ч зарим сумд хяналт тавьж ажиллаагүй байна. Аймгийн ЗДТГ-ын СТСХэлтсээс төсөл арга хэмжээний ажлын гүйцэтгэл болон гэрээний заалтыг баримтлан санхүүжилтийг олгож ирсэн байна.

Аймгийн ЗД-ын дэргэдэх ГХБХБГ-аас ОНХС-аар хийгдэж буй барилга угсралтын ажилд захиалагчийн хяналтыг тавьж ирсэн байна. Үүнд:

* Арвайхээр сумын 10, 11-р багийн өрхийн эмнэлгийн барилга угсралтын ажилд тус газраас 21 удаагийн үе шатны хяналтыг хийж, 18-н үүрэг даалгаврыг өгч ажилласан.

* Арвайхээр сумын 3,4,7,8-р багийн өрхийн эмнэлгийн барилга угсралтын ажилд тус газраас 16 удаагийн үе шатны хяналтыг хийж, 15-н үүрэг даалгавар өгч ажилласан.

* Арвайхээр сумын 1,2,9-р багийн өрхийн эмнэлэг барилга угсралтын ажилд тус газраас 15 удаагийн үе шатны хяналтыг хийж, 9-н үүрэг даалгаврыг өгсөн.

* Баян-Өндөр сумын 50 хүүхдийн цэцэрлэгийн өргөтгөлийн барилга угсралтын ажлын явцад 6 удаагийн үе шатны хяналтыг хийж суурийн хэмжилт, шал, багана цутгалт, өрлөг, дээвэр, заслын ажлуудад үе шатны хяналтыг тавьж тухай бүр үүрэг даалгавар өгч ажилласан.

* Баруунбаян-Улаан сумын 50 хүүхдийн цэцэрлэгийн өргөтгөлийн барилга угсралтын ажилд тус газраас 6 удаагийн хяналт хийсэн байна.

* Хархорин сумын Эрдэнэтолгой баг, Арцатын гэр хорооллын автозамын ажлыг хийх ажилд аймгийн ЗДТГ-ын ХОХБТХэлтсээс захиалагчийн хяналтыг тавьж, замын хөрсийг нягтруулах туршилт, цементээр бэхжүүлсэн суурь 20 см, асфальто бетон хучилт 5 см, тэнхлэгийн координат болон хучилтын өргөнийг хэмжсэн хэмжилтийн хуудас, асфальтобетон хучилтын дагуу огтлолын зураг, асфальтобетон хучилтын хөндлөн огтлолын гүйцэтгэлийн зураг зэргийг үйлдсэн байна.

ОНХСангийн хөрөнгөөр санхүүжигдсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд Баруунбаян-Улаан, Баянгол Богд, Төгрөг, Гучин-Ус сумд ажлын хэсэг байгуулан ажлын явцад хяналт тавьж ажилласан байна.

Бусад сумдад захиалагчийн зүгээс ОНХС-ийн хэрэгжилтийн явцад хяналт тавьсан материал байхгүй байна.

Хүснэгт 3: ОНХС-ийн санхүүжилтийг сумдад өгсөн хуваарь

/сая төгрөг/

Д/д	Сумын нэр	Нийт эх үүсвэр		Зарцуулалт Санхүүжүүлсэн дүн	Оны эцсийн дансны үлдэгдэл
		Урьд оны	ОНХС-аас олгосон		
1	Баян-өндөр	25.8	90.1	114.6	1.3
2	Бүрд	9.1	85.6	94.4	
3	Бат-Өлзий	4.4	103.7	82.0	26.1
4	ББУлаан	14.8	122.3	137.1	-
5	Баянгол		88.9	88.9	-
6	Гучин-Ус		102.4	102.4	-
7	Есөнзүйл		79.2	79.2	-
8	Өлзийт		74.9	74.9	-
9	ЗБУлаан		81.6	81.6	-
10	Богд	57.2	139.1	184.9	11.3
11	Нарийнтээл		94.2	94.2	-
12	Сант		80.2	80.2	-
13	Тарагт		83.4	83.3	0.1
14	Төгрөг	6.2	110.1	99.6	16.7
15	Уянга		123.9	114.0	9.9
16	Хдулаан		104.4	96.3	8.1
17	Хужирт		156.1	156.1	-
18	Хархорин	5.0	137.8	142.8	-
19	Арвайхээр		227.4	226.8	0.6
20	Аймгийн ОНХСан	97.9	1427.5	1520.3	5.1
	Дүн	220.4	3512.8	3654.0	79.2

Аймгийн төрийн сан ОНХС-аас орж ирсэн санхүүжилтийг төсвийн хуваарийн дагуу сумдад олгож ирсэн, оны эцэст санхүүжилт орж ирсэнээс 79.2 сая төгрөг аймаг, сумдын дансанд үлдэгдэлтэй гарсан байна.

График 2: ОНХС-ийн нийт эх үүсвэр, илэрсэн зөрчлийн харьцааг графикаар харуулбал

/сая төгрөг/

ОНХСангийн нийт эх үүсвэр, илэрсэн зөрчлийн харьцаа /сүүлийн 3 жилээр/



Аудитаар захиалагчийн хяналт тавиагүй болон бусад төсөл арга хэмжээ:

- Сант сумын гудамжны гэрэлтүүлгийн 5.0 сая төгрөгийн ажил хийгдсэн боловч хүлээж аваагүй,
- Баян-Өндөр сумын төвийн ерөнхий төлөвлөгөөний ажлын тендер зарлаж 25.5 сая төгрөгийн санхүүжилтээ олгосон боловч тендерийн хугацаа зөрчигдсөнөөс тендер хүчингүй болж ОНХСанд буцаан төвлөрүүлсэн зэрэг нийтдээ 2 төсөл арга хэмжээний 30.5 сая төгрөгийн албан шаардлага тавигдаж байна.

Зөвлөмж: Аймгийн Засаг дарга Г.Ганболд болон сумдын Засаг дарга нарт:

- Захиалагчаас тавих хяналтаа сайжруулах.

2.7 ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийг “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулийн дагуу бүртгэл тайланд тусгаж ирсэн байна.⁷

Аймаг, сумд ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийг бүртгэл тайландаа орлого авч тусгаж ирсэн байна.

Харин Богд сумын “Төвийн 7 дугаар багийн 1,2,3 дугаар хорооллын цахилгаан хангамжийг сайжруулах ажил” -ыг 29,7 сая төгрөгөөр “Тэнгэр Номадс” ХХК-тай гэрээ байгуулсан боловч ажил дуусаагүй бүртгэлд тусгаагүйд албан шаардлага өгч байна.

Гурав. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг зохион байгуулаагүй, хэрэгжилтийг зааврын дагуу тайлагнаагүй байна.

3.1. Аймаг сумдын ИТХ болон аймгийн ЗД-ын дэргэдэх СХДАХэлтсээс 2016 оны ОНХС-ийн хэрэгжилтийн явцад хяналт тавиагүй байна.⁸

Аймгийн ИТХТэргүүлэгчдийн 2017 оны 04 дүгээр сарын 10-ны 02 тоот хуралдааны тэмдэглэлээр 2014-2015 оны ОНХСан болон сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагааг шалгасан дүнгийн тухай асуудлыг аймгийн ЗД-н дэргэдэх СХДАХэлтсийн дарга Л.Хатанбаатар танилцуулсан ба хурлаар аймгийн Засаг дарга Г.Ганболдод дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг үүрэг болгосон байна. Үүнд:

⁷ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4.Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэе: 14.4.2.бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага;

⁸ “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 9-ын 1-д ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад хяналт шалгалтын байгууллагууд, тухайи орон нутгийн ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо, иргэд, иргэний нийгмийн байгууллагууд хяналт тавьж ажиллана.

- Аймгийн хэмжээнд шинээр баригдах барилга байгууламж, хийгдэх их засвар, шинэчлэлийн асуудлыг хэлэлцэж, орон нутгийн хэрэгцээ шаардлагын дагуу эрэмбэлсэн жагсаалтыг 2017-2020 онд баримталж ажиллах.
- Сумдын ОНХС-ийн худалдан авах ажиллагааны хууль зөрчсөн байдал, зориулалт бусаар зарцуулсан зардлуудын талаар тодорхой ажлын чиглэл гаргаж, буруутай хүмүүст арга хэмжээ тооцох, цагдаа, хууль хяналтын байгууллагад шилжүүлэх зэрэг арга хэмжээ авч ажиллах гэсэн үүрэг өгөгджээ.

Үүнээс өөр хяналт тавьсан баримт материал байхгүй байна.

Зөвлөмж: Аймгийн ИТХ-ын дарга А.Ишдорж, Засаг дарга Г.Ганболд болон сумдын ИТХ-ын дарга, Засаг дарга нарт:

- ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хянах ИТХ-ын дэргэдэх хяналтын хороо болон дотоод аудитыг ажиллуулах, захиалагчийн хяналтыг тухай бүр явуулж байх.

3.2. Аймаг сумдын ОНХС-ийн хэрэгжилтийн тайланг "Орон нутгийн хөгжлийн сангийн заавар"-ын дагуу хүргүүлээгүй, тайланд дүн шинжилгээ хийгээгүй байна.⁹

Сангийн сайдын 2014 оны 43 тушаалаар баталсан ОНХС-ийн зааварт зааснаар:

Тухайн шатны ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо нь сайн дурын идэвхтэн иргэд, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ОНХС-аас хэрэгжсэн хөтөлбөр, төсөл, арга хэмжээний үр дүнд хяналт тавьж, үнэлгээ хийнэ.

Аймгийн ЗДТГ нь аймгийн түвшинд сумын ОНХС-ийн хэрэгжилтийг санхүүгийн болон бусад хяналт-шинжилгээ, үнэлгээний үзүүлэлтээр мэдээллийн сан байгуулах, мэдээллийн санг холбогдох мэдээллээр тогтмол баяжуулж байх.

Сумд ОНХС-ийн хэрэгжилтийн явцын хагас бүтэн жилийн тайланг аймгийн ЗДТГ-ын хөгжлийн бодлогын хэлтэст хүргүүлнэ. ОНХС-ийн хэрэгжилтийн үр дүнгийн жилийн эцсийн тайланд дүн шинжилгээ хийж, ажлын үр дүнг танилцуулах үүрэг бүхий ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтсийн даргаар ахлуулсан ажлын хэсгийг Засаг даргын захирамжаар тухай бүр томилж ажиллуулна.

Ажлын хэсэг ОНХС-ийн хэрэгжилтийн байдалд дүгнэлт өгөн, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал, зөвлөмжийг сум бүрээр гарган аймгийн Засаг даргад танилцуулж, шаардлагатай бол тухайн шатны ИТХ-аар хэлэлцүүлнэ гэж тусгаж өгсөн боловч аймаг сумдын ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо хяналт тавиагүй, аймгийн ЗДТГ-ын ХОХБТХэлтсээс тайланг нэгтгэж, дүн шинжилгээ хийгдээгүй байна.

Зөвлөмж: Аймгийн Засаг дарга Г.Ганболдод:

- Аймаг сумдын ОНХС-ийн тайланг хагас бүтэн жилээр нэгтгэн дүн шинжилгээ хийж байх.

3.3. ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж буй ажлын санхүүжилтийн мэдээллийг зааврын дагуу мэдээлсэн байна.

Аймаг сумдын ИТХ-аар батлагдсан ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжигдэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний жагсаалт, төсөвт өртгийг иргэдэд Засгийн газрын худалдан авах

⁹ "Орон нутгийн хөгжлийн сангийн заавар"-ын 10-ын 1-д Сум, дүүргийн ОНХС-ийн хэрэгжилтийн явцын хагас жилийн тайланг жил бүрийн 7 дугаар сарын 10-ний дотор, бүтэн жилийн тайланг дараа оны 2 дугаар сарын 1-ний дотор аймаг, нийслэлийн ЗДТГ-ын хөгжлийн бодлогын хэлтэст хүргүүлнэ. ОНХС-ийн хэрэгжилтийн үр дүнгийн жилийн эцсийн тайланд дүн шинжилгээ хийж, ажлын үр дүнг танилцуулах үүрэг бүхий ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтсийн даргаар ахлуулсан ажлын хэсгийг Засаг даргын захирамжаар тухай бүр томилж ажиллуулна.

10.2 Ажлын хэсэг ОНХС-ийн хэрэгжилтийн байдалд дүгнэлт өгөн, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал, зөвлөмжийг сум дүүрэг бүрээр гарган аймаг, нийслэлийн Засаг даргад танилцуулж, шаардлагатай бол тухайн шатны ИТХ-аар жил бүрийн 2 дугаар сарын 25-ний дотор хэлэлцүүлнэ

ажиллагааны сайт, өдөр тутмын сонин, телевиз, сумдын веб сайт, самбараар иргэдэд ил тод мэдээлж ирсэн байна.

Аймаг сумд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний мэдээллийг мэдээллийн самбар болон байгууллагын цахим хуудас, шилэн дансны нэгдсэн сайтад байршуулжээ.

3.4. “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар” нь Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 2-ын 12, 58 дугаар зүйлийн 4-ийн 3 дахь заалтуудтай зөрчилдөж байна.

Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 2-д аймаг өөрийн төсвөөр тухайн шатанд хамаарах дараах чиг үүргийг бие даан хэрэгжүүлнэ. “ ... 58 дугаар зүйлийн 2-ын 12-д мал, амьтны халдварт өвчинтэй тэмцэх, хортон шавжийн устгал, хяналт, гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн хор хохирлыг арилгах ... гэж заасан бөгөөд хуулийн 60 дугаар зүйлийн 3-д Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг дараах зүйд зарцуулахыг хориглоно. 60 дугаар зүйлийн 3-ын 1-д орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргээс бусад хөтөлбөр, арга хэмжээ. Мөн хуулийн 60 дугаар зүйлийн 4-д энэ хуулийн 60 дугаар зүйлийн 3-ын 1-д заасан хуулиар тогтоосон чиг үүрэгт аймаг, нийслэл, сум, дүүргийн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэг хамаарахгүй гэж зааж өгсөн байна.

Гэвч Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэхээр гаргасан Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-т аймгийн ОНХС-аар хийгдэх ажлын жагсаалтад “...гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн хор хохирлыг арилгах” талаар журамлагдаагүй байгаа нь төсвийн тухай хуультай зөрчилдөж байна гэж үзэж байна.

Мөн хуулийн 58 дугаар зүйлийн 4-д сум өөрийн төсвөөр дараах чиг үүргийг бие даан хэрэгжүүлнэ. “... 58 дугаар зүйлийн 4-ийн 3-д сумын нутаг дэвсгэр дэх нийтийн эзэмшлийн аж ахуйн үйлчилгээ, нийтийн ариун цэвэр, гудамж талбайн гэрэлтүүлэг, цэвэрлэгээ, хог зайлуулалтыг хийх гэж заасан байхад Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-т хог зайлуулалтыг хийх талаар сумдад хогийн төвлөрсөн цэг байгуулах, хог боловсруулах жижиг хэмжээний үйлдвэр байгуулах, хог тээврийн авто тээврийн хэрэгсэл нийлүүлэх гэж журамласан байх ба хог зайлуулалтын хөлс, тээвэр, шатахууны зардлын талаар тусгагдаагүйгээс зөрчил үүсэж байна.

ҮАГ-т уламжлах нь:

- Төсвийн тухай хууль болон Орон нутгийн хөгжлийн сангийн зааврын зөрчилдсөн заалтыг арилгуулах талаар холбогдох байгууллагад санал тавих.

3.5 Өмнөх оны аудитаар өгөгдсөн акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

Өмнөх оны аудитаар өгөгдсөн акт, албан шаардлага, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Дүгнэлт:

Нэг. Аймгийн ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэрийг хууль, журамд заасны дагуу төлөвлөөгүй, орлогын нэр төрлөөр бүрдүүлээгүй ч хууль, журмын дагуу хуваарилсан байна.

1.1 Аймгийн ОНХС-аас олгох орлогын шилжүүлгийг батлагдсан аргачлалын дагуу орон нутгийн хөгжлийн индекс, хүн амын тоо, хүн амын нягтрал, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээ, орон нутгийн татварын идэвх санаачилга зэргийг харгалзан тооцож төлөвлөсөн байна.

1.2 Аймаг, сумдын ОНХС-ийн эх үүсвэрийг төлөвлөхдөө төсвийн төсөл боловсруулах журамд заасан нэр төрлөөр тооцож төлөвлөөгүй байна.

1.3 Аймаг, сумдын ОНХС-ийн эх үүсвэрийг хуульд заасан ОНХНС-аас хуваарилагдсан шилжүүлгийн орлогоос бүрдүүлж, бусад эх үүсвэрийг дайчлан ажиллаж чадаагүй байна.

1.4 Аймгийн ОНХС-аас олгосон шилжүүлгийг аймагт 40 хувь, сумдад 60 хувийн харьцаагаар хууль, журмын дагуу хуваарилж, батлагдсан хуваарийн дагуу санхүүжилтийг жигд хийгдээгүйгээс зарим сумдад санхүүжилтийг бүрэн олгоогүй байна.

Хоёр. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг хууль журмын дагуу зохион байгуулсан ч хөрөнгийг зориулалт бусаар зарцуулах, ажлыг дутуу буюу чанаргүй хийх, гэрээт хугацааг хэтрүүлэх, санхүүжилтээ аваад ажлаа хийгээгүй төсөл арга хэмжээ гарсан байна.

2.1 Аймаг, сумд ОНХС-ийн хөрөнгийг орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулан төлөвлөж, урьдчилсан саналын жагсаалтыг бэлтгэж ажилласан байна.

2.2 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-г иргэдэд нээлттэй хэлэлцүүлэн санал авч байгаа боловч төсвийн хүрэлцээ хомс, урд онуудын саналын эрэмбэлэлтээр ажил хийгдээгүй хойшилсноос иргэдээс авах санал авалт багассан байна.

2.3 "Орон нутгийн хөгжлийн сангийн заавар"-ын 4.7 дахь заалтын шаардлагыг хангасан ТАХ-г хэрэгжүүлсэн байна.

2.4 Төсөл, хөтөлбөрийн гүйцэтгэчийг сонгон шалгаруулах ажлыг хууль журмын дагуу зохион байгуулсан ч зарим нэг тендерийн шалгаруулалт тодорхойгүй байна.

2.5 ОНХС-ийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулах, дутуу буюу чанаргүй хийх, гэрээт хугацааг хэтрүүлэх, санхүүжилтээ аваад ажлаа хийгээгүй төсөл арга хэмжээ гарсаар байна.

2.6 Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд захиалагчийн хяналтыг аймгийн ЗДТГ-ын ХОХБТХэлтэс болон ЗД-ын дэргэдэх ГХБХБГ-аас тавьж ирсэн ч зарим сумд хяналт тавьж ажиллаагүй байна. Аймгийн ЗДТГ-ын СТСХэлтсээс төсөл арга хэмжээний ажлын гүйцэтгэл болон гэрээний заалтыг баримтлан санхүүжилтийг олгож ирсэн байна.

2.7 ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийг "Нягтлан бодох бүртгэлийн тухай" хуулийн дагуу бүртгэл тайланд тусгаж ирсэн байна.

Гурав. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг зохион байгуулаагүй, хэрэгжилтийг зааврын дагуу тайлагнаагүй байна.

3.1. Аймаг сумдын ИТХ болон аймгийн ЗД-ын дэргэдэх СХДАХэлтсээс 2016 оны ОНХС-ийн хэрэгжилтийн явцад хяналт тавиагүй байна.

3.2. Аймаг сумдын ОНХС-ийн хэрэгжилтийн тайланг "Орон нутгийн хөгжлийн сангийн заавар"-ын дагуу хүргүүлээгүй, тайланд дүн шинжилгээ хийгээгүй байна.

3.3. ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж буй ажлын санхүүжилтийн мэдээллийг зааврын дагуу мэдээлсэн байна.

3.4. "Орон нутгийн хөгжлийн сангийн заавар" нь Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 2-ын 12, 58 дугаар зүйлийн 4-ийн 3 дахь заалтуудтай зөрчилдөж байна.

3.5 Өмнөх оны аудитаар өгөгдсөн акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

Зөвлөмж:

Өвөрхангай аймгийн ИТХ-ын дарга А.Ишдорж, Засаг дарга Г.Ганболд нарт:

- Аймгийн ОНХС-ийн орлогыг төлөвлөхдөө төсвийн зарлагын бодит хэмнэлт, хандив, тусламжийн хөрөнгийг төвлөрүүлэх, хууль, журамд заасан орлогын бусад эх үүсвэрийг дайчлан төлөвлөж, шийдвэртээ тусган хэрэгжүүлэх.

Аймгийн Засаг дарга Г.Ганболдод:

- ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг иргэдээр нээлттэй хэлэлцүүлж байх.
- Барилгын экспертээр хянагдаж батлагдсан зураг төсвөөр төсөл арга хэмжээг хэрэгжүүлж байх.
- Төсөл, хөтөлбөрийн гүйцэтгэчийг сонгон шалгаруулах ажлыг хууль, журмын дагуу зохион байгуулж байх.
- Аймаг сумдын ОНХС-ийн тайланг хагас бүтэн жилээр нэгтгэн дүн шинжилгээ хийж байх.

Аймгийн Засаг дарга Г.Ганболд болон сумдын Засаг дарга нарт:

- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан, ажлыг чанаргүй, дутуу гүйцэтгэсэн байгууллага, аж ахуйн нэгжийн удирдлага, хүмүүст хариуцлага тооцох.
- Гүйцэтгэл дутуу байгаа болон санхүүжилтээ аваад ажлаа хийгээгүй төсөл арга хэмжээг энэ оны эхний хагас жилд багтаан дуусгаж хүлээн авах.
- Захиалагчаас тавих хяналтаа сайжруулах.

Аймгийн ИТХ-ын дарга А.Ишдорж, Засаг дарга Г.Ганболд болон сумдын ИТХ-ын дарга, Засаг дарга нарт:

- ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хянах ИТХ-ын дэргэдэх хяналтын хороо болон дотоод аудитыг ажиллуулах, захиалагчийн хяналтыг тухай бүр явуулж байх.

Аймгийн Засаг даргын 2017 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 1/190 албан тоотоор ирүүлсэн ОНХСангийн 2016 оны зарцуулалтанд хийсэн нийцлийн аудитын тайлангийн төсөлд ирүүлсэн саналыг хүлээж авах боломжгүй байна.

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ӨВӨРХАНГАН АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2017 оны 07 сарын 28

Дугаар 4/02

Арвайхээр

Нийцлийн аудитын тайланг
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5, 15 дугаар зүйлийн 15.1.4 дахь заалтын бүрэн эрхийн хүрээнд УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2017 оны 02 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/92 дугаар тушаалаар батлагдсан "Гүйцэтгэлийн аудитын журам"-ын 12 дугаар зүйлийн 12.40, 2014 оны 121 дүгээр "Нийслэлийн болон аймгийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторруудад зөвшөөрөх бүрэн эрхийн тухай" тушаал Монгол Улсын Ерөнхий аудиторт аймгийн Аудитын газраас 2017 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус аймгийн 2016 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтад хийсэн нийцлийн аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Нийцлийн аудитаар илэрсэн зөрчлийн жагсаалтыг нэгдүгээр хавсралтаар баталсугай.
3. Аудитаар өгөгдсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, биелэлтийг 2017 оны 06 дугаар сарын 20-ны дотор гаргаж ирүүлэхийг аймгийн Засаг дарга /Г.Ганболд/, сумдын Засаг дарга нарт зөвлөсүгэй.
4. Аудитаар өгөгдсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2017 оны 3 дугаар улиралд багтаан удирдлагын зөвлөлд танилцуулахыг аудитын мөнөжөр /Ц.Отгонням/-д үүрэг болгосугай.
5. Аудитын тайланг Үндэсний аудитын газар, аймгийн нийцлийн аудитын газар, аймгийн ИТХурлын дарга /А.Ишдорж/, аймгийн Засаг дарга /Г.Ганболд/ нарт тус тус хүргүүлсүгэй.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Л.ЛАМААЧИН